



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/107

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2023 оны 4 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 8 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цас их орж өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад хүнсний тусламжаар олгох 55 тн Цагаан будааг Улаанбаатар хотоос аймгийн төв хүртэл тээвэрлэх зардалд 3.000.000 (Гурван сая) төгрөг, Рашаант сумын төвөөр урсдаг Цэнгэлийн голд их хэмжээний халиа үүсч шар усны үет авсан тул далан барьж гудамж хороолол айл өрхийн шар уснаас хамгаалах, усны ургалыг боож зогсоох ажлын шатахууны болон бусад шаардлагатай зардалд 5.000.000 (Таван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх зардлын 8.000.000 (Найман сая) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас, гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ